

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 35 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 14 цаг 11 минутад эхэлж, 15 цаг 46 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 35 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Буянхүүгийн Батдэлгэрийг Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Буянхүүгийн Батдэлгэрийг Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Говьсүмбэр аймгийн Засаг дарга Л.Одсэрт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын Хөрөнгийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар

		<p>сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгийн зах зээлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд Түндэвийн Жамбаажамцад дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Х.Бум-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
3	<p>Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 1.4, Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 40, 59 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 7 дугаарт заасан Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний 6)-д “Аймгийн Ерөнхий прокурор,” гэснийг “Аймгийн Цагдаагийн газрын дэд дарга,” гэж өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

4	Ховд аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Ховд аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Цэнд-Аюушийн Оюунчимэгийг томилох.</p> <p>2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 19-д “...Магваны Отгонхишиг” гэснийг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Оюунчимэгт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Иргэн А.Айбекийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөөс хасах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын гуравдугаар бүлгийн 6.5, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын гуравдугаар бүлгийн 3.2.5, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. “Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 2013 оны 167 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын “Дэс түшмэлийн ангиллын</p>

		<p>төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын 1; Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс; Нийгмийн халамж, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан алба; мэргэжилтэн гэсний "Асхарын Айбек; 65", мөн тогтоолын есдүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын 9; Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс; Нийгмийн халамж, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан алба; мэргэжилтэн гэсний "Асхарын Айбек; 65" гэсэн хэсгийг тус тус хасах</p> <p>2. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Баян-Өлгий аймаг дах Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга Т.Манкейд анхааруулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Соёл спорт аялал жуулчлалын яамны Соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах	<p>Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн П.Алтангэрэлийн 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 2/4459 тоот албан бичгээр Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтов.</p>
7	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын	<p>Худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах</p>

	<p>удирдах албан тушаалд томилуулахаар санал болгож байгаа зарим албан хаагчдад гаргах Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийн тухай</p> <ul style="list-style-type: none"> - Бараа худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга - Цахим худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга 	<p>ажиллагааны хэлтсийн даргын, Бараа худалдан авах ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдэд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гарган нэр дэвшүүлэх боломжгүй тул буцаахаар шийдвэрлэв.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ